

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Олборлох салбарын ил тод байдлын (Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын) тухай хууль

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Монгол Улсын ДНБ-ний 20 орчим хувь, экспортын орлогын 90 гаруй хувь, хөдөлмөрийн зах зээлд 50000 орчим ажлын байр шууд бий болгож байдаг эрдэс баялгийн салбараас гадна Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх ёстой ой, ус, амьтан, байгалийн ургамлын ашиглалтын үйл ажиллагааг “олборлох үйлдвэрлэл” -ийн ойлголтод хамруулан, тэдгээрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж дээрх салбаруудад ил тод, тогтвортой байдлын үндэсний тогтолцоо бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулаад байна.

Олборлох салбарын ил тод байдлын (Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын) тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг анх Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаа байгуулсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/ Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар баталсан байна.

Хуулийн төсөл боловсруулах явцад гадаад улс орны туршлага, жишгийг судлахад олон улсад тухайлсан салбарын ил тод байдлыг хангах бие даасан зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлж байгаа хандлага нилээд байсан. Тухайлбал, Европын холбооны ил тод байдлын удирдамж, Канад улсын олборлох салбарын ил тод байдлыг хэмжих тухай хууль, Канад Улсын газар эзэмшигчдийн ил тод байдлын тухай хууль, АНУ-ын хуулийн этгээдийн ил тод байдлын тухай хууль зэрэг кодекс харилцаа бүхий хууль тогтоомжууд батлагдан хэрэгжиж байна. Түүнчлэн олборлох салбарын ил тод байдлын олон улсын санаачлага зэрэг нилээд хэдэн олон улсын санаачлага, хөтөлбөрүүд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах, авлигыг бууруулах зэрэг зорилгын хүрээнд олон улсад хэрэгжсээр иржээ.

Харин Монгол Улсын Засгийн газраас 2006 онд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжих тухай” 1 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэйгөөр байгуулан ажиллах болсноор манай улс албан ёсоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай олон улсын санаачилга”-ыг хэрэгжүүлж эхэлсэн нь Монгол Улс олборлох үйлдвэрлэл ялангуяа уул уурхайн салбар дахь ил

тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалан хэрэгжүүлж ирсний нэг илрэл юм.

Олборлох салбарын засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах, эцсийн эзэмшигч, өмчлөгчийг тодорхой болгох, авлига, мөнгө угаах болон санхүүгийн бусад гэмт хэргийн гаралтыг бууруулах, шударга бус өрсөлдөөн, давамгайл байдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулах зорилгоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл 4 бүлэг бүлэг, 26 зүйлтэйгээр боловсруулагдсан.

Хуулийн үйлчлэх хүрээ буюу олборлох үйлдвэрлэлд зөвхөн Ашигт малтмалын тухай хуульд заасан ашигт малтмалаар хязгаарлах бус бусад хуулиар зохицуулдаг ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хамруулахаас гадна байгалийн бусад баялаг болох амьтан, ургамал, ойн баялгийн ашиглалтын үйл ажиллагаанд мөн ил тод байдлыг хангах нийтлэг зохицуулалт бүхий бие даасан хуультай болох нь оновчтой гэж үзэж байна.

Олборлох салбар дахь төр болон бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах нь тухайн улс орны байгалийн баялгийн нөөцийг хэрхэн удирдаж, ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа талаар мэдээ, мэдлэгийг нэмэгдүүлдэг. Энэ нь олборлох үйлдвэрлэл болон түүний зөвшөөрлийг эзэмшиж байгаа этгээд хэн болох, түүнд ямар санхүүгийн нөхцөл хамаарч байгаа, олборлох үйлдвэрлэлд зарцуулсан зардал, олж байгаа орлого, түүний зарцуулалтын зэрэг мэдээлэл рүү илүү төвлөрүүлдэг байна. Эдгээр мэдээллийг ил тод болгох нь байгалийн баялгийн нөөц, хөрөнгө, орлогыг өндөр үр ашигтайгаар ашиглах, зарцуулахад суурь тулгуур болж өгөх юм.